



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2023

XXX ХОРОО

СТАТИСТИК
ҮЗҮҮЛЭЛТ



www.ubstat.mn



www.facebook.com/BGD.stat



www.1212.mn

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
30 ХОРОО | **2023**



Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

Хуудасны
дугаар

	ХОРООНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	7
	НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ	8
	ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	9
	ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ, СУУЦНЫ НӨХЦӨЛ	23
	БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ	27
	ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ	29
	БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 30 ДУГААР ХОРООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эцэст	7
ХҮСНЭГТ 2. ДҮҮРЭГ, ХОРООНЫ ӨРХ, ХҮН АМЫН ТОО, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст...	9
ХҮСНЭГТ 3. СУУРИН ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ТОО, жил бүрийн эцэст	10
ХҮСНЭГТ 4. СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйс, насны бүлгээр, жил бүрийн эцэст	11
ХҮСНЭГТ 5. ХҮН АМЫН ТОО, хүйс, насны бүлгээр, хүйсийн харьцаа, 2023 оны жилийн эцэст	12
ХҮСНЭГТ 6. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, улс, нийслэл, жил бүрийн эцэст	13
ХҮСНЭГТ 7. ХҮН АМЗҮЙН АЧААЛАЛ, жил бүрийн эцэст.....	14
ХҮСНЭГТ 8. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, насны ангилалаар, жил бүрийн эцэст	15
ХҮСНЭГТ 9. ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО, хүйс, ам бүлийн тоогоор, жил бүрийн эцэст	16
ХҮСНЭГТ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн эцэст	17
ХҮСНЭГТ 11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний төрөл, хэлбэрээр, 2023 оны жилийн эцэст	18
ХҮСНЭГТ 12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний төрөл, хэлбэрээр, жилийн эцэст	19
ХҮСНЭГТ 13. ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эцэст	20
ХҮСНЭГТ 14. ИХЭР ХҮҮХДИЙН ТОО, өрх, хүүхдийн тоогоор, жил бүрийн эцэст	20
ХҮСНЭГТ 15. I, II ЗЭРГИЙН ОДОНТОЙ ЭХ, ХҮҮХДИЙН ТОО, насны бүлгээр, жил бүрийн эцэст	22
ХҮСНЭГТ 16. ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, жил бүрийн эцэст.....	24
ХҮСНЭГТ 17. ТЕЛЕВИЗОР, ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ТОО, ангилалаар, жил бүрийн эцэст	25
ХҮСНЭГТ 18. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, жил бүрийн эцэст	28
ХҮСНЭГТ 19. ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн эцэст	29
ХҮСНЭГТ 20. НИЙТИЙН ХООЛ, АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн эцэст	30
ХҮСНЭГТ 21. БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, жил бүрийн эцэст	31
ХҮСНЭГТ 22. ҮЙЛ АЖИЛЛАГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, хариуцлагын хэлбэрээр, жил бүрийн эцэст	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, 1 га нутаг дэвсгэрт ногдох хүн амын нягтрал, жил бүрийн эцэст	8
ЗУРАГ 2. ХҮН АМЫН ТОО, жилийн дундаж өсөлтийн хувь, жил бүрийн эцэст	9
ЗУРАГ 3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2022, 2023 оны жилийн эцэст	10
ЗУРАГ 4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, жил бүрийн эцэст, дүнд эзлэх хувиар	11
ЗУРАГ 5. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, хүйс, улс, нийслэлээр	13
ЗУРАГ 6. ХҮН АМЗҮЙН АЧААЛАЛ, дүүрэг, хороогоор, жил бүрийн эцэст	14
ЗУРАГ 7. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст	15
ЗУРАГ 8. ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст	16
ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, тоогоор, жил бүрийн эцэст	16
ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2023 оны жилийн эцэст	17
ЗУРАГ 11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний хэлбэрээр, жил бүрийн эцэст	18
ЗУРАГ 12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТОО, сургуульд хамрагдалтаар, жил бүрийн эцэст	19
ЗУРАГ 13. ГАНЦ БИЕЭРЭЭ АМЬДАРЧ БУЙ АХМАД НАСТАН, хүйсээр, жил бүрийн эцэст	20
ЗУРАГ 15. ОДОНТОЙ ЭХИЙН ТОО, хүүхдийн тоогоор, 2023 оны жилийн эцэст	21
ЗУРАГ 16. ДҮҮРГИЙН 30 ДУГААР ХОРООНЫ ӨРХИЙН ТОО, дундаж ам бүл, жил бүрийн эцэст	23
ЗУРАГ 17. ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2023 оны жилийн эцэст	23
ЗУРАГ 18. ӨРХИЙН ТОО, ам бүлийн тоогоор, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2023 оны жилийн эцэст	24
ЗУРАГ 19. ТЕЛЕВИЗОР, ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, хувиар, жил бүрийн эцэст	25
ЗУРАГ 20. НОХОЙ, МУУРНЫ ТОО, жил бүрийн эцэст	26
ЗУРАГ 21. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, өсөлт, бууралтын хувь, илрүүлэлтийн хувиар, жил бүрийн эцэст	27
ЗУРАГ 22. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ангилалаар, жил бүрийн эцэст	27
ЗУРАГ 23. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, үйлдэгдсэн байдлаар, жил бүрийн эцэст	28
ЗУРАГ 24. ДЭЛГҮҮРИЙН ТОО, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2023 оны жилийн эцэст	30
ЗУРАГ 25. БҮРТГЭЛТЭЙ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, жил бүрийн эцэст	31
ЗУРАГ 26. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, 2023 оны жилийн эцэст	32

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 30 ДУГААР ХОРООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эцэст


Үзүүлэлт	2021	2022	2023
Өрхийн тоо	-	1 773	1 740
Хүн амын тоо	-	6 360	6 017
Эрэгтэй	-	3 001	2 855
Эмэгтэй	-	3 359	3 162
Ахмад настан	-	709	706
Хүн амын нягтрал, га-д ногдох	-	307.7	291.1
Хөдөлмөрийн насны хүн	-	3 383	3 138
Хүн амзүйн ачаалал	-	62.3	63.2
Хагас өнчин хүүхдийн тоо	-	36	28
Бүтэн өнчин хүүхдийн тоо	-	2	1
Өрх толгойлсон хүний тоо	-	23	12
Үүнээс: Өрх толгойлсон эмэгтэй	-	19	12
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	-	132	63
Ганц биеэрээ өрх үүсгэн амьдарч буй ахмад настан	-	7	9
Телевизортой өрхийн тоо	-	1 773	1 740
Үүнээс: 1 телевизортой өрхийн тоо	-	1 598	1 608
Компьютертэй өрхийн тоо	-	1 193	1 150
Интернэтэд холбогдсон	-	1 018	1 150
Нохойны тоо	-	14	24
Муурны тоо	-	2	5
Бүртгэгдсэн гэмт хэрэг, тоогоор	-	-	12
Дэлгүүрийн тоо	-	14	16
Нийтийн хоол	-	-	-
Бүртгэлтэй ААНБ-ын тоо	-	-	47
Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо	-	-	13

НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ



Баянгол дүүргийн 30 дугаар хороо нь нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12/36 дугаар тогтоолоор баянгол дүүргийн 6 дугаар хорооны цэсийг шинэчлэн баталж 30 дугаар хороог шинээр байгуулсан. тус хороо нь 20.6 га газар нутагтай, 1730 өрхийн, 6360 хүн амтай, 5 сууц өмчлөгчдийн холбооны 40 нийтийн байр, 53 амин орон сууцнаас бүрдсэн 100% байшин хороолол ба 68 аж ахуй нэгж байгууллага байрлаж үйл ажиллагаагаа явуулж байна. хорооны нутаг дэвсгэрт төрийн өмчит 114 цэцэрлэг, ашуис-н харъяа сувилахуйн сургууль, эм зүйн сургууль, оснаауг хүт-14 төв мөн ачтан эмнэлэг, протезийн үйлдвэр зэрэг томоохон аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, 1 га нутаг дэвсгэрт ногдох хүн амын нягтрал, жил бүрийн эцэст



Баянгол дүүргийн 1 га нутаг дэвсгэрт 2017 онд 75, 2018, 2019 онуудад 77, 2020 онд 79, 2021 онд 80, 2022 онд 84 хүн, 2023 онд 101 хүн оршин сууж байгаа бол харин 30 дугаар хорооны 1 га нутаг дэвсгэрт 2022 онд 307, 2023 онд 291 хүн тус тус оршин сууж байна.

ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ



Хүн амын үндсэн үзүүлэлтүүд болох төрөлт, нас баралт, шилжилт хөдөлгөөнөөр хүн амын тоог тодорхойлдог. Хүн амын тооны өөрчлөлт нь улс орны тухайн үеийн нийгэм, эдийн засгийн хөгжил, ард түмний аж байдлын түвшин, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг олон хүчин зүйлтэй уялддаг.


Баянгол дүүргийн 30 дугаар хороонд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 1740 өрхөд 6017 хүн байнга оршин сууж байгаагийн 2855 (47.4%) нь эрэгтэй, 3162 (52.6%) нь эмэгтэй байна. Өнгөрсөн 2022 оны үзүүлэлтээс 33 (1.9%) өрх, 343 (5.4%) хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 2. ДҮҮРЭГ, ХОРООНЫ ӨРХ, ХҮН АМЫН ТОО, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023
	тоо		
Өрхийн тоо	-	1 773	1 740
Дүүргийн өрхийн тоо	-	65 543	69 519
Дүүргийн дүнд эзлэх хувь	-	2.7	2.5
Хүн амын тоо	-	6 360	6 017
Дүүргийн хүн ам	-	246 886	252 979
Дүүргийн дүнд эзлэх хувь	-	2.6	2.4

2023 онд тус хороонд Баянгол дүүргийн нийт өрхийн 2.5 хувь, хүн амын 2.4 хувь нь тус тус амьдарч байна.

ЗУРАГ 2. ХҮН АМЫН ТОО, жилийн дундаж өсөлтийн хувь, жил бүрийн эцэст



Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг харвал 2023 онд 5.7 хувь болж буурсан байна. 2021 онд өрх, хүн амын тоо огцом буурсан нь 2021 онд Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор хорооны хилийн цэст өөрчлөлт орж 28 дугаар хороо руу өрх, хүн амын тоо шилжсэнтэй холбоотой юм.


30 дугаар хорооны хүн амын жилийн дундаж тоо нь өнгөрсөн оноос 3008 (94.6%) хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 3. СУУРИН ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ТОО, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	$\frac{2023}{2022}$
	тоо			хувь
Жилийн эхний хүн ам	-	-	6 360	-
Жилийн эцсийн хүн ам	-	6 360	6 017	94.6
Хүн амын жилийн дундаж тоо	-	3 180	6 188	1.9 ¹

Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж, дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого, хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог. Хүн амын төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд, залуучууд, идэр насныхан эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг.

ЗУРАГ 3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2022, 2023 оны жилийн эцэст



Хүн амын нас хүйсийн 2022 оны суварга нь дунд хэсгээрээ өргөсөж байгаа нь хүн ам идэршиж байгааг харуулж байна. Хорооны хүн амын насны бүтцийг 2022 онтой харьцуулахад зарим өөрчлөлт гарсан ба нийт хүн амд эзлэх 0-9 насныхны хувийн жин өссөн нь 2011 оноос төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой. Гэвч сүүлийн 5 жил төрөлт буурах хандлагатай байна.

2022 оны нас хүйсийн суварга дээшлэх тусам нарийсаж байгаа нь зөвхөн төрөлтийн нөлөө төдийгүй нас нэмэгдэх тусам нас баралт өсөж байгаагаас шалтгаалж байна. Мөн өндөр настай


эмэгтэйчүүдийн нас баралт эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад бага байгаа нь суваргаас харагдаж байна.

ХҮСНЭГТ 4. СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйс, насны бүлгээр, жил бүрийн эцэст

Насны бүлэг	2021		2022		2023	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
	тоо					
Дүн	-	-	6 360	3 359	6 017	3 162
0-4	-	-	647	311	567	259
5-9	-	-	745	356	728	347
10-14	-	-	681	330	663	320
15-19	-	-	360	178	378	186
20-24	-	-	348	189	295	168
25-29	-	-	368	191	311	164
30-34	-	-	577	300	488	257
35-39	-	-	651	357	609	327
40-44	-	-	468	242	448	233
45-49	-	-	420	228	414	218
50-54	-	-	297	162	311	172
55-59	-	-	229	140	221	122
60-64	-	-	200	129	211	139
65-69	-	-	162	107	162	104
70+	-	-	207	139	211	146

30 дугаар хорооны нийт хүн амын 57.0 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлж байна. Тодруулбал нийт хүн амын 38.8 (2336 хүн) хувь нь 0-18 насны хүүхэд, 51.5 (3097 хүн) хувь нь 19-59 насны хүмүүс, үлдсэн 9.7 (584 хүн) хувь нь 60 ба түүнээс дээш насны өндөр настан тус тус эзэлж байна.

ЗУРАГ 4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, жил бүрийн эцэст, дүнд эзлэх хувиар



30 дугаар хороонд хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурч байгааг харж болно. Нийт хүн амд хөдөлмөрийн насны иргэдийн эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлдөг.

ХҮСНЭГТ 5. ХҮН АМЫН ТОО, хүйс, насны бүлгээр, хүйсийн харьцаа, 2023 оны жилийн эцэст

Нас, насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нас, насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
ДҮН	6 017	2 855	3 162	90.3	50	80	36	44	81.8
0	99	47	52	90.4	51	71	34	37	91.9
1	108	55	53	103.8	52	44	22	22	100.0
2	110	57	53	107.5	53	58	26	32	81.3
3	117	69	48	143.8	54	58	21	37	56.8
4	133	80	53	150.9	55	47	26	21	123.8
5	143	70	73	95.9	56	51	24	27	88.9
6	120	65	55	118.2	57	51	23	28	82.1
7	149	76	73	104.1	58	28	13	15	86.7
8	141	81	60	135.0	59	44	13	31	41.9
9	175	89	86	103.5	60	47	17	30	56.7
10	133	68	65	104.6	61	43	12	31	38.7
11	149	77	72	106.9	62	42	11	31	35.5
12	130	60	70	85.7	63	45	15	30	50.0
13	119	67	52	128.8	64	34	17	17	100.0
14	132	71	61	116.4	65	39	12	27	44.4
15	98	44	54	81.5	66	36	15	21	71.4
16	94	52	42	123.8	67	33	13	20	65.0
17	61	27	34	79.4	68	25	8	17	47.1
18	73	45	28	160.7	69	29	10	19	52.6
19	52	24	28	85.7	70	20	5	15	33.3
20	53	19	34	55.9	71	25	10	15	66.7
21	58	21	37	56.8	72	13	3	10	30.0
22	67	28	39	71.8	73	21	8	13	61.5
23	56	27	29	93.1	74	15	2	13	15.4
24	61	32	29	110.3	75	23	9	14	64.3
25	61	24	37	64.9	76	8	3	5	60.0
26	51	17	34	50.0	77	12	4	8	50.0
27	51	26	25	104.0	78	13	2	11	18.2
28	80	48	32	150.0	79	15	3	12	25.0
29	68	32	36	88.9	80	9	3	6	50.0
30	66	29	37	78.4	81	7	2	5	40.0
31	96	38	58	65.5	82	3	2	1	200.0
32	114	59	55	107.3	83	4	3	1	300.0
33	109	58	51	113.7	84	4	1	3	33.3
34	103	47	56	83.9	85	6	2	4	50.0
35	127	61	66	92.4	86	1	1	-	-
36	134	52	82	63.4	87	3	1	2	50.0
37	136	70	66	106.1	88	1	-	1	-
38	115	59	56	105.4	89	-	-	-	-
39	97	40	57	70.2	90	3	-	3	-
40	118	53	65	81.5	91	-	-	-	-
41	90	46	44	104.5	92	1	-	1	-
42	90	46	44	104.5	93	2	-	2	-
43	74	32	42	76.2	94	-	-	-	-
44	76	38	38	100.0	95	-	-	-	-
45	93	51	42	121.4	96	1	-	1	-
46	67	29	38	76.3	97	1	1	-	-
47	78	31	47	66.0	98	-	-	-	-
48	91	44	47	93.6	99	-	-	-	-
49	85	41	44	93.2	100+	-	-	-	-

Төрөх үеийн хүйсийн харьцаа нь 2023 онд 0 настай хүүхэд нь 90.4 байсан ба энэ нь 100 эмэгтэй хүүхэд тутамд 90 эрэгтэй хүүхэд төрж байгааг илтгэж байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 4-18 насанд эрэгтэйчүүд ихэнхдээ давамгайлж төрсөн байдаг ч нас ахих тусам хүйсийн харьцаа эсрэгээр болж буурдаг байна. Энэ нь эрэгтэйчүүдийн эрт нас баралттай буюу дундаж наслалт багатай холбоотой юм.

Баянгол дүүргийн 30 дугаар хорооны хүн амын нас хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 2022 онд 89.3 байсан бол 2023 онд 90.3 болжээ.

Дундаж наслалт нь шинээр төрсөн хүүхдийн эрүүл мэнд, амьдрах нөхцөл нь цаашид хэвээр хадгалагдана гэж үзвэл түүний үргэлжлэн амьдрах жилээр тооцсон дундаж хугацааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тухай хугацаанд шинээр төрсөн хүүхдийн цаашид амьдрах дундаж хугацааг тодорхойлох “таамаглах хэмжигдэхүүн” юм.

Дундаж наслалтын үзүүлэлт нь аливаа улс орны эрүүл мэндийн салбарын хөгжлийн хүрсэн түвшнийг харуулдаг чухал үзүүлэлт бөгөөд хүний хөгжлийн индексийн тооцоо, тэтгэврийн нас тогтоох, даатгалын байгууллагуудын эрсдэлийн тооцоо хийх зэрэг төлөвлөлтүүдийг хийхэд ашиглагддаг.

ХҮСНЭГТ 6. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, улс, нийслэл, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Улаанбаатар	71.51	71.65	71.8	72.09	72.32	72.31	72.24
Улсын дундаж	69.89	70.19	70.41	70.71	71.01	71.28	71.5
Нийслэл, улсын дунджийн зөрүү	1.62	1.46	1.39	1.38	1.31	1.03	0.74

Нийслэлийн хүн амын дундаж наслалт 2023 онд 72.24 болж, өмнөх оноос 0.07 жилээр богиноссон байна. 2017 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт улсын дунджаас 1.62 жилээр илүү байсан бол 2023 оны байдлаар 0.74 жилээр илүү болжээ.

ЗУРАГ 5. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, хүйс, улс, нийслэлээр



Нийслэлийн хүн амын дундаж наслалтыг хүйсээр нь авч үзвэл шинэ төрсөн эрэгтэй хүүхэд дундажаар 67.6 жил, эмэгтэй хүүхэд 75.6 жил амьдрах магадлалтай байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2013 онд 9.6 байсан бол 2023 онд 9.2 болсон байна.

Дундаж наслалт нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд нэлээд ялгаатай байдгаас уг тооцоог эрэгтэй, эмэгтэй хүн амын хувьд тусдаа хийх нь төлөвлөлтийн олон талын ач холбогдолтой юм.

ХҮСНЭГТ 7. ХҮН АМЗҮЙН АЧААЛАЛ, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> 2022
	тоо			хувь
0-14 насны хүн ам	-	2 073	1958	94.4
65 ба түүнээс дээш насны хүн ам	-	369	373	109.4
15-64 насны хүн ам	-	3 918	3686	95.9
Хүн ам зүйн ачаалал	-	62.3	63.2	100.5


Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ. 2023 оны байдлаар хүн ам зүйн ачаалал 63.2 болж өмнөх оноос 0.9 нэгж хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн бүр 63 хүнийг тэжээж байна.

Хүн амын төрөлтийн түвшин өндөр байснаас шалтгаалан хүүхдийн хүн ам зүйн ачаалал 2023 оны байдлаар 53.1 байгаа бол хөгшидийн ачаалал 10.1 байна.



60-аас дээш насны 706 өндөр настны 72.4 хувь эрэгтэй, 27.6 хувь нь эмэгтэй байна.

ЗУРАГ 6. ХҮН АМЗҮЙН АЧААЛАЛ, дүүрэг, хороогоор, жил бүрийн эцэст



Хорооны хүн ам зүйн ачаалал нь дүүргийн хүн ам зүйн ачаалалаас 0.1-0.8 нэгж хувиар илүү байна. Харин 2023 онд 0.8 хувиар илүү байна.

НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Хагас, бүтэн өнчин хүүхэд: 2023 онд нийт өнчин хүүхдийн тоо 29 байгаа ба 1 (3.4%) хүүхэд бүтэн өнчин, 28 (96.6%) хүүхэд хагас өнчин байна. Бүтэн өнчин хүүхэд өмнөх оноос 1 (50.0%) хүүхдээр, хагас өнчин хүүхэд 8 (22.2%) хүүхдээр буурсан байна.


ХҮСНЭГТ 8. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, насны ангилалаар, жил бүрийн эцэст

Насны ангилал	Бүтэн өнчин хүүхэд				Хагас өнчин хүүхэд			
	2021	2022	2023	<u>2023</u> <u>2022</u>	2021	2022	2023	<u>2023</u> <u>2022</u>
				хувь				хувь
Дүн	-	2	1	50.0	-	36	28	77.8
0-4	-	-	-	-	-	2	-	-
5-9	-	-	-	-	-	11	5	45.5
10-14	-	1	-	-	-	15	15	100.0
15-17	-	1	1	100.0	-	8	8	100.0

¹-дахин их

Харин хагас өнчин хүүхдүүдийн 27.4 хувь нь 5-9 насны, 41.9 хувь нь 10-14 насны, 27.4 хувь нь 15-17 насны хүүхдүүд тус тус эзэлж байна.


ЗУРАГ 7. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст



Бүтэн өнчин хүүхдүүдийн 1 (100.0%) нь, хагас өнчин хүүхдүүдийн 14 (50.0%) нь эмэгтэй хүүхэд байна.

Өрх толгойлсон эцэг, эх: 2023 онд нийт өрх толгойлсон эцэг, эхчүүдийн тоо 12 болж өмнөх оноос 11 (47.8%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс өрх толгойлсон эх 12 (100.0%) болж өмнөх оноос 7 (36.8%), өрх толгойлсон эцэг 0 (0%) болж 4 (100.0%) хүнээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 8. ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст




Өрх толгойлсон эцэг, эхийн тоог ам бүлийн тоогоор авч үзвэл 3-5 ам бүлтэй 12 (100.0%) өрх байна. Үүнээс 12 (100.0%) өрх 18 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх эзэлж байна.

ХҮСНЭГТ 9. ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО, хүйс, ам бүлийн тоогоор, жил бүрийн эцэст

Ам бүлийн тоо	Нийт өрх толгойлсон эцэг, эх			Үүнээс: Өрх толгойлсон эмэгтэй		
	2021	2022	2023	2021	2022	2023
Дүн	-	23	12	-	19	12
3 хүртэл	-	4	-	-	2	-
3-5	-	18	12	-	16	12
6, түүнээс дээш	-	1	-	-	1	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам: 2023 оны жилийн эцсийн байдлаар тус хороонд 132 хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 12 (10.0%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, тоогоор, жил бүрийн эцэст




Хөгжлийн бэрхшээлтэй хүний 63 (47.7%) эмэгтэйчүүд, 31 (23.5%) хувь нь хүүхэд байна. Хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй 5 (3.8%) хүн байна.

ХҮСНЭГТ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн эцэст

Хороо	2021		2022		2023	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
	тоо					
Дүн	-	-	120	56	132	63
0-4	-	-	2	1	4	1
5-9	-	-	2	-	14	4
10-14	-	-	4	1	8	3
15-17	-	-	3	1	5	3
18-19	-	-	-	-	1	-
20-34	-	-	5	1	9	4
35-64	-	-	66	37	64	35
65-аас дээш	-	-	38	15	27	13

2023 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 4 (3.0%) нь 0-4 насны, 14 (10.6%) нь 5-9 насны, 8 (6.1%) нь 10-14 насны, 6 (4.5%) нь 15-19 насны, 9 (6.8%) нь 20-34 насны, 64 (48.5%) нь 35-64 насны, 27 (20.5%) 65-аас дээш настай байна.

ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2023 оны жилийн эцэст



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 21 (15.9%) нь төрөлхийн, үлдсэн 111 (84.1%) нь өвчнөөр болон осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Нийт олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог төрлөөр авч үзвэл 102 (77.3%) хүн ердийн өвчнөөр, 1 (0.8%) хүн мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр, 1 (0.8%) хүн зам тээврийн ослоор, 8 (6.0%) хүн үйлдвэрийн болон ахуйн ослоор хөгжлийн бэрхшээлтэй болсон

байна.


ХҮСНЭГТ 11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний төрөл, хэлбэрээр, 2023 оны жилийн эцэст

Өвчний хэлбэр	Бүгд	Төрөлхийн	Олдмол	Үүнээс:				
				Өвчнөөр		Осол гэмтлээр		
				Ердийн өвчин	МШӨ ²	Зам тээвэр	Үйлдвэрлэлийн осол	Ахуйн осол
	тоо							
Дүн	132	21	111	102	1	-	4	4
Хараа	8	2	6	6	-	-	-	-
Яриа	-	-	-	-	-	-	-	-
Сонсгол	12	-	12	12	-	-	-	-
Хөдөлгөөн	24	3	21	17	-	-	2	2
Сэтгэц	13	7	6	6	-	-	-	-
Хавсарсан	16	5	11	11	-	-	-	-
Бусад	59	4	55	50	1	-	2	2

²-Мэргэжлээс шалтгаалах өвчин

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог өвчний төрлөөр авч үзвэл 8 (6.1%) хүн харааны, 0 (0%) хүн яриа, 12 (9.1%) хүн сонсголын, 24 (18.2%) хүн хөдөлгөөний, 13 (9.8%) хүн сэтгэцийн, 16 (12.1%) хүн хавсарсан, 59 (44.7%) хүн бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний хэлбэрээр, жил бүрийн эцэст



Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэлбэрээс нь харвал өнгөрсөн оноос ярианы бэрхшээлтэй хүн 100 хувиар, харааны бэрхшээлтэй хүн 38.5 хувиар, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүн 50.0 хувиар буурсан бол, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн 33.3 хувиар, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй иргэн 50.0 хувиар, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүн 40.5 хувиар тус тус өссөн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 21 (15.9%) нь байнгын асаргаанд байна. Энэ нь өнгөрсөн жилээс 7 (50.0%) хүнээр өссөн байна.


ХҮСНЭГТ 12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний төрөл, хэлбэрээр, жилийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> 2022
				хувь
Бүгд	-	120	132	110.0
Өвчний төрлөөр				
Төрөлхийн	-	9	21	2.3 ¹
Олдмол	-	111	111	100.0
Хэлбэрээр				
Хараа	-	13	8	61.5
Яриа	-	2	0	-
Сонсгол	-	12	12	60.0
Хөдөлгөөн	-	16	24	150.0
Сэтгэц	-	3	13	4.3 ¹
Хавсарсан	-	32	16	50.0
Бусад	-	42	59	140.5

1-дахин

Нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2023 оны байдлаар 40 (30.3%) байгаа бөгөөд өнгөрсөн жилээс 40 (100.0%) хүн буурсан байна.

ЗУРАГ 12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТОО, сургуульд хамрагдалтаар, жил бүрийн эцэст



2023 оны жилийн эцсийн байдлаар тус хороонд сургуульд сурдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байхгүй байна.

Нийгмийн зарим үзүүлэлт: Нийт өрхийн 229 (13.2%) нь 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх байна. Энэ нь өнгөрсөн оноос 151 (1.9 дахин) хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 13. ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> 2022
	тоо			хувь
18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх	-	78	229	2.9 ¹
Ганц биеээрээ өрх үүсгэн амьдарч буй ахмад настай хүн	-	7	9	128.6

¹-дахин их

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт өрхийн 9 (0.5%) нь ганц биеээрээ өрх үүсгэн амьдарч буй ахмад настан байгаагаас 3 (33.3%) нь 60, түүнээс дээш настай эрэгтэй, 6 (66.7%) нь 55, түүнээс дээш настай эмэгтэй байна.

ЗУРАГ 13. ГАНЦ БИЕЭРЭЭ АМЬДАРЧ БУЙ АХМАД НАСТАН, хүйсээр, жил бүрийн эцэст



Хорооны хэмжээнд 2023 оны жилийн эцэст 2 ихэр хүүхэдтэй 16 өрхөд 32 хүүхэд байна. Өнгөрсөн жилээс ихэр хүүхдийн тоо 2 (6.7%) өссөн байна.


ХҮСНЭГТ 14. ИХЭР ХҮҮХДИЙН ТОО, өрх, хүүхдийн тоогоор, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> 2022
	тоо			хувь
Ихэр хүүхэдтэй өрх	-	15	16	106.7
Хоёр ихэр хүүхэдтэй	-	15	16	106.7
Гурван ихэр хүүхэдтэй	-	-	-	-
Ихэр хүүхдийн тоо	-	30	32	106.7
Хоёр ихэр хүүхэд	-	30	32	106.7
Гурван ихэр хүүхэд	-	-	-	-

Үндэсний Статистикийн хорооны даргын 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/100 тоот тушаалаар Нийгмийн үзүүлэлтийн жилийн мэдээний маягтыг шинэчлэн баталсны дагуу 2018 оноос “Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонтой эх”-ийн мэдээллийг нэгтгэн гаргадаг болсон.

2023 оны жилийн эцсийн байдлаар тус хороонд алдарт эхийн одонтой 232 эх байгаагийн 41 (17.7%) нь 1 дүгээр зэргийн одонтой, 191 (82.3%) нь 2 дугаар зэргийн одонтой эхчүүд байна.


ЗУРАГ 14. ОДОНТОЙ ЭХИЙН ТОО, жил бүрийн эцэст



Өнгөрсөн жилээс 46 (16.5%) одонтой ээжээр өссөн ба 1 дүгээр зэргийн одонтой 10 (19.6%) ээжээр, 2 дугаар зэргийн одонтой 36 (15.9%) ээжээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар тус хороонд 232 эхийн 1057 хүүхэд амьдарч байна. Мөн алдарт эхийн 1 дүгээр зэргийн одонтой эхийн нийт хүүхдийн тоо 241 бол 1 эхэд ногдох хүүхдийн дундаж тоо 6, алдарт эхийн 2 дугаар зэргийн одонтой эхийн нийт хүүхдийн тоо 816 бол 1 эхэд ногдох хүүхдийн дундаж тоо 4 байна.

ЗУРАГ 145. ОДОНТОЙ ЭХИЙН ТОО, ХҮҮХДИЙН ТООГООР, 2023 оны жилийн эцэст



Нийт алдарт эхийн одонтой ээжүүдийг насны бүлгээр нь харвал 65-69 насныхан хамгийн их буюу 17.2 хувийг, хамгийн бага нь 25-29 насныхан 0 хувийг эзэлж байна. Харин хүүхдийн тоогоор нь харвал 65-69 насныхан хамгийн их хүүхэдтэй байгаа нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 15. I, II ЗЭРГИЙН ОДОНТОЙ ЭХ, ХҮҮХДИЙН ТОО, насны бүлгээр, жил бүрийн эцэст

Насны ангилал	2021		2022		2023	
	I зэргийн одон	II зэргийн одон	I зэргийн одон	II зэргийн одон	I зэргийн одон	II зэргийн одон
	ТОО					
Эхийн дүн	-	-	51	227	41	191
25-29	-	-	-	4	-	-
30-34	-	-	-	4	-	2
35-39	-	-	5	7	1	15
40-44	-	-	2	28	2	26
45-49	-	-	1	24	2	28
50-54	-	-	1	10	-	11
55-59	-	-	4	15	1	5
60-64	-	-	5	17	1	17
65-69	-	-	4	34	5	35
70-74	-	-	5	32	11	20
75-79	-	-	7	25	11	19
80-84	-	-	12	18	4	9
85-89	-	-	4	8	1	3
90-94	-	-	1	1	1	1
95+	-	-	-	-	1	-
Хүүхдийн дүн	-	-	306	1 010	241	816
25-29	-	-	-	16	-	-
30-34	-	-	-	16	-	8
35-39	-	-	30	38	6	63
40-44	-	-	12	116	12	105
45-49	-	-	6	98	11	113
50-54	-	-	6	42	-	45
55-59	-	-	24	68	6	20
60-64	-	-	30	78	7	73
65-69	-	-	24	144	30	159
70-74	-	-	30	138	67	85
75-79	-	-	42	114	68	84
80-84	-	-	72	96	18	44
85-89	-	-	24	40	5	13
90-94	-	-	6	6	6	4
95+	-	-	-	-	5	-

Алдарт эхийн одонтой ээжүүдийн хүүхдүүдийг насны бүлгээс нь харвал 24 (2.3%) хүүхэд 0-4 насны, 76 (7.2%) хүүхэд 5-9 насны, 102 (9.6%) хүүхэд 10-14 насны, 77 (7.3%) хүүхэд 15-18 насны, 28 (2.6%) хүн нь 19 настай, 750 (71.0%) нь 20, түүнээс дээш настай байна.


ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ, СУУЦНЫ НӨХЦӨЛ



2023 оны жилийн эцэст Баянгол дүүргийн 30 дугаар хороонд 1740 өрх аж төрж байна. Тус хороо нь 100 хувь орон сууцны хороо юм.


Өрхийг илэрхийлэх өөр нэг үзүүлэлт нь 1 өрхөд ногдох хүний тоо юм. Нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 2022 онд 3.6 ам бүл ногдож байгаа бол 2023 онд 3.5 ам бүл ногдож байна. Тус хорооны дундаж ам бүл ихэвчлэн 3 байна.

ЗУРАГ 156. ДҮҮРГИЙН 30 ДУГААР ХОРООНЫ ӨРХИЙН ТОО, дундаж ам бүл, жил бүрийн эцэст



Хорооны өрхийн тоо өмнөх оноос 33 (1.9%) өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 167. ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2023 оны жилийн эцэст




Монгол Улсын өрхийн ам бүлийн бүтэц нь хүн амын өсөлттэй уялдан өөрчлөгдсөөр ирсэн байна.

Нийт өрхийн 60.2 хувь нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, 39.8 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй.

Хорооны нийт өрхийн 261 (15.0%) нь 2 ам бүлтэй өрх, 292 (16.8%) нь 3 ам бүлтэй өрх, 341 (19.6%) нь 4 ам бүлтэй өрх, 263 (15.1%) нь 5 ам бүлтэй өрх, 155 (8.9%) нь 6 ам бүлтэй өрх, 55 (3.2%) нь 7 ам бүлтэй өрх, 36 (2.1%) нь 8 ам бүлтэй өрх, 23 (1.3%) нь 9 ам бүлтэй өрх, 27 (1.6%) нь 10, түүнээс дээш ам бүлтэй өрх

тус тус эзэлж байна. Харин ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй хүн 287 (16.5%) байна.

ЗУРАГ 178. ӨРХИЙН ТОО, ам бүлийн тоогоор, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2023 оны жилийн эцэст



Эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 22.5 хувь нь 2 ам бүлтэй өрх буюу хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувьд 4 ам бүлтэй өрх хамгийн өндөр буюу 21.8 хувийг эзэлж байна. Аль ч цаг үед 3-4 ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин хамгийн өндөр байна.

ХҮСНЭГТ 16. ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, жил бүрийн эцэст

Сууцны төрөл		2021	2022	2023	<u>2023</u> 2022
		тоо			хувь
Нийт өрх		-	1 773	1 740	98.1
Үүнээс:	Орон сууцны хорооллын өрхийн тоо	-	1 773	1 740	98.1
	Нийтийн орон сууц	-	1 540	1 642	106.6
	Тусдаа тохилог орон сууц	-	233	98	42.1
	Орон гэргүй	-	-	-	-
Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх %		-	100.0	100.0	100.0

2023 оны жилийн эцсийн байдлаар тус хороонд өрх бүгдээрээ нийтийн орон сууцад амьдарч байна.

Телевизор, компьютертэй өрх: Дүүргийн 30 дугаар хороонд 2023 оны жилийн эцэст телевизортой өрх 1740 байсан бөгөөд эдгээрийн 92.4 хувь нь нэг телевизортой ажээ.


ХҮСНЭГТ 177. ТЕЛЕВИЗОР, ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ТОО, ангилалаар, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> 2022
	тоо			хувь
Телевизортой өрхийн дүн	-	1 773	1 740	98.1
1 телевизортой	-	1 598	1 608	100.6
2 телевизортой	-	175	132	75.4
3 телевизортой	-	-	-	-
4 телевизортой	-	-	-	-
Компьютертэй өрхийн дүн	-	1 193	1 150	96.4
Үүнээс: Интернэтэд холбогдсон өрх	-	1 018	1 150	113.0
Зөөврийн компьютер	-	458	468	102.2

Мөн хорооны нийт өрхийн 1150 (66.1%) нь гэртээ компьютертэй ба бүгд интернэтэд холбогдсон байна. Нийт компьютертэй өрхийн 40.7 хувийг нь зөөврийн компьютертэй өрх эзэлж байна.


Өмнөх онтой харьцуулахад хорооны нийт өрхөд 33 (1.9%) телевизорээр, компьютертэй өрхийн тоо 43 (3.6%) тус тус буурсан байна.

ЗУРАГ 189. ТЕЛЕВИЗОР, ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, хувиар, жил бүрийн эцэст



Нохой, муурны бүртгэл: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Журам батлах тухай” 222 дугаар тогтоолыг үндэслэн жил бүрийн эцэст мал тооллогын хугацаанд шинэчлэн нэгтгэдэг. Нохой, муурны 2023 оны бүртгэлийг шинэчилсэн бөгөөд бүртгэлээр 24 нохой, 5 муур бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 10 (71.4%) нохой, 3 (1.5 дахин) муураар тус тус өссөн өөрчлөлттэй байна.

ЗУРАГ 190. НОХОЙ, МУУРНЫ ТОО, жил бүрийн эцэст




БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ



Баянгол дүүргийн 30 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2023 оны жилийн эцэст 12 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 201. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, өсөлт, бууралтын хувь, илрүүлэлтийн хувиар, жил бүрийн эцэст



Дүүргийн 30 дугаар хорооны хэрэг бүртгэлийн 12 хэргээс 7 хэргийг ялдагдагчаар татаж илрүүлэлт 58.3%-тай байна.

Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилдаг болсон. 2023 оны жилийн эцсийн байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12 (100.0%) нь хөнгөн хэрэг, үлдсэн 0 (0%) нь хүнд хэрэг тус тус эзлээд байна.

ЗУРАГ 212. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ангилалаар, жил бүрийн эцэст




30 дугаар хороонд 2023 оны жилийн эцэст бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 41.7 хувийг залилан, 25.0 хувийг хулгайн, 8.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 25.0 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 188. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, жил бүрийн эцэст

Төрөл		2021	2022	2023	<u>2023</u> <u>2022</u>
					хувь
Нийт гэмт хэрэг		-	-	12	-
Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах	-	-	-	-
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	-	-	-	-
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	-	-	1	-
	Хүчиндэх	-	-	-	-
	Хулгайлах	-	-	3	-
	○ Иргэдийн өмчийн	-	-	3	-
	○ Авто тээврийн хэрэгслийн	-	-	-	-
	○ Халаасны	-	-	-	-
	○ Бусад	-	-	-	-
	Дээрэмдэх	-	-	-	-
	Залилах	-	-	5	-
	ХАБТХАЖЭ ²	-	-	-	-
	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	-	-	-
	Бусад	-	-	3	-

¹-дахин²-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

ЗУРАГ 223. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, үйлдэгдсэн байдлаар, жил бүрийн эцэст



2023 оны жилийн эцэст нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 3 (100.0%) нь гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг байна.

ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ



Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цэгийн захиргааны статистик мэдээгээр 30 дугаар хороонд 2023 оны байдлаар нийт 36 үйлчилгээний цэг байгаа нь өмнөх оноос 7 (24.1%) үйлчилгээний цэгээр өссөн ба дэлгүүр 2 (14.3%), ахуйн үйлчилгээ 3 (300.0), гэр ахуйн барааны засвар үйлчилгээ 3 (37.5%) нэгжээр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин түргэн үйлчилгээний цэг 1 (33.3%) тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 199. ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн эцэст

Хороо	2021		2022		2023	
	Бүгд	ААНБ	Бүгд	ААНБ	Бүгд	ААНБ
	тоо					
Дүн	-	-	29	22	36	23
Худалдааны төв	-	-	-	-	-	-
Бөөний худалдааны төв	-	-	-	-	-	-
Түргэн үйлчилгээний цэг	-	-	3	-	2	-
Дэлгүүр	-	-	14	11	16	11
Хүнсний жижиг, дунд үйлдвэр	-	-	3	3	3	3
Нийтийн хоол	-	-	-	-	-	-
Ахуйн үйлчилгээ	-	-	1	-	4	2
Гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	-	-	8	8	11	7
Сургалт	-	-	-	-	-	-

2023 оны эцэст 30 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт үйлчилгээний цэгийн 23 (63.9%) нь ААНБ-ын, үлдсэн 13 (36.1%) нь иргэдийн эзэмшлийн цэгүүд эзэлж байна.

Нийт үйлчилгээний цэгийн 5.6 хувийг түргэн үйлчилгээний цэгүүд, 44.4 хувийг дэлгүүр, 8.3 хувийг хүнсний жижиг, дунд үйлдвэрлэл, 11.1 хувийг ахуйн үйлчилгээ, 30.6 хувийг гэр ахуйн барааны засвар үйлчилгээний байгууллагууд тус тус эзэлж байна.

Дүүргийн 30 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт дэлгүүрийн 1 (6.3%) нь хүнсний бус барааны дэлгүүр, 15 (93.7%) нь хүнсний дэлгүүр эзэлж байна. Мөн нийт хүнсний дэлгүүрийн 6.7 хувийг супермаркет, 33.3 хувийг 6 нэрийн хүнсний дэлгүүр, 60 хувийг 8 нэрийн хүнсний дэлгүүр тус тус эзлээд байна.

ЗУРАГ 234. ДЭЛГҮҮРИЙН ТОО, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2023 оны жилийн эцэст



2023 оны эцэст тус хороонд нийтийн хоолны үйлчилгээ явуулдаг байгууллага байхгүй байна.

ХҮСНЭГТ 200. НИЙТИЙН ХООЛ, АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> <u>2022</u>
	тоо			Хувь
Нийтийн хоол	-	-	-	-
Зоогийн газар	-	-	-	-
Цайны газар (гуанз)	-	-	-	-
Бар	-	-	-	-
Кафе	-	-	-	-
Ахуйн үйлчилгээ	-	1	1	-
Үсчин	-	1	1	-
Гоо сайхан	-	-	-	-

¹-дахин

Тус хорооны нутаг дэвсгэрт ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1 байгууллага байгаагийн 100 хувь нь үсчиний үйлчилгээний газар эзэлж байна.


БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА



Аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн дугаар, хөрөнгө, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ (аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ), ажиллагчдын тоо, цалин, үйл ажиллагааны чиглэл зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг багтаасан мэдээллийн санг [Статистикийн бизнес регистр](#) гэнэ.

Статистискийн бизнес регистрийн мэдээллийн санд 2023 оны эцэст 30 дугаар хороонд нийт 47 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 13 (27.7%) нь үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 245. БҮРТГЭЛТЭЙ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, жил бүрийн эцэст



1-дахин

30 дугаар хороонд бүртгэлтэй 47 аж ахуйн нэгж, байгууллагын 27.7 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа бол 72.3 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

ХҮСНЭГТ 211. БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> 2022
	тоо			хувь
Дүн	-	-	47	-
Үйл ажиллагаа явуулж байгаа	-	-	13	-
Үйл ажиллагаа эхлээгүй байгаа	-	-	30	-
Үйл ажиллагаа түр зогссон	-	-	4	-
Үйл ажиллагаа бүрэн зогссон	-	-	-	-
Бусад	-	-	-	-

1-дахин

Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар нэгжийг эдийн засгийн бүх төрлийн салбарын ангилал 3.0, 3.1, 4.0 хувилбаруудаар бүртгэдэг бөгөөд энэхүү танилцуулгад Сангийн сайдын 103 тоот тушаалаар 2011 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC) хувилбар 4.0-ын дагуу тоо, мэдээллийг гаргалаа. Энэхүү ангиллаар аж ахуйн нэгж, байгууллагыг ямар төрлийн үйл ажиллагаа явуулж байгаагаас нь хамааруулан дараах салбаруудад ангилдаг.

ЗУРАГ 256. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, 2023 оны жилийн эцэст



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаас харвал хамгийн их буюу 53.8 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, харин хамгийн бага нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа ба захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа гэх мэт байна.

2023 оны жилийн эцэст үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 92.3 хувь нь компани, 7.7 хувь нь төрийн бус байгууллага байна.

ХҮСНЭГТ 222. ҮЙЛ АЖИЛЛАГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, хариуцлагын хэлбэрээр, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	<u>2023</u> 2022
	тоо			хувь
Дүн	-	-	13	-
Компани	-	-	12	-
Нөхөрлөл, хоршоо	-	-	-	-
Төсөвт байгууллага	-	-	-	-
Төрийн бус байгууллага	-	-	1	-

¹-дахин

2023 онд бизнес регистрийн санд бүртгэлтэй 30 дугаар хороон үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцлагын хэлбэрээр авч үзвэл 92.3 хувь нь компани, 7.7 хувь нь төрийн бус байгууллага байна.

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Б.ЭРХЭМБАЯР

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Б.ШИНЭЦЭЦЭГ

МЭРГЭЖИЛТЭН

Хаяг:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
27-р хороо, Замчдын гудамж-3
Засаг даргын тамгын газрын байр
114 тоот

Утас:

11-301637, 70122688

Цахим хаяг:

bayangol@nso.mn

Цахим хуудас:

<http://www.1212.mn>
<http://www.ubstat.mn>
<http://www.bgd.mn>

